

 МННХ(Соросын сан)-гийн  
Нээлттэй Мэдээлэл Төв



# СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(ТББ-ын онлайн мэдээллийн хэрэгцээ)

Улаанбаатар хот  
2003 он

## Оршил

1997 онд Монголын ТББ-ын тухай хуулийг баталсан билээ. 2003 оны хоёрдугаар сарын байдлаар Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны албан ёсны бүртгэлтэй 2900 гаруй ТББ үйл ажиллагаагаа явуулж байна.

ТББ-уудыг үйл ажиллагааных нь чиглэлээр хүүхэд, залуучууд; жендер, гэр бүл; хүний эрх, иргэний нийгэм, ардчилал; нийгмийн халамж, эмзэг бүлэг болон тахир дутуу иргэд; эдийн засаг, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ; спорт, аялал жуулчлал, чөлөөт цаг; боловсрол, шинжлэх ухаан, технологи, судалгаа; мэдээлэл, олон нийтийн хэвлэл мэдээлэл; олон улсын найрамдал, хамтын ажиллагаа; эрүүл мэнд; мэргэжил, сонирхлын бүлгүүд; хууль эрх зүй; байгаль орчин, байгалийн гамшиг; соёл урлаг, утга зохиол, түүх дурсгал; ахмад; бүс нутаг, орон нутгийн хөгжил гэсэн үндсэн бүлгүүдэд хуваан үздэг.

ТББ-ууд улс орондоо иргэний ардчилсан нээлттэй нийгмийг байгуулж хөгжүүлэхэд идэвхтэй оролцож, нийгэм, эдийн засаг, соёл боловсрол, мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх, ажилгүйдэл ба ядуурлыг бууруулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг явуулж байна.

Өнгөрсөн хугацаанд ТББ-уудын дунд явуулсан судалгаа, санал асуулгуудаас дурдвал:

- “ТББ-ын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь” судалгаа, АСЛИС холбоо ТББ, (МННХ)
- “Төрийн бус байгууллагын судлал” судалгаа, “Зотол” мэргэжлийн социологчдын клуб ТББ, (МННХ)
- “Нээлттэй Мэдээлэл Төвийн үйл ажиллагааг өргөтгөн сайжруулах, үйл ажиллагааны хэтийн төлөв болон ТББ-уудын эрэлт хэрэгцээг тодорхойлох” маркетингийн судалгаа, Интернэт ба Мэдээлэл төв ТББ,
- “Монголын нийгмийн салбарт ТББ-уудын оруулсан хувь нэмэр” судалгаа, (НҮБХХ)
- “ТББ-уудын ажилтнуудыг сургах хэрэгцээ шаардлага” судалгаа, ТББ-ын Сургууль ТББ,
- “ТББ-уудын хэрэгцээг тодруулах” санал асуулга, МННХ (Соросын сан)

Дээр дурдсан судалгаа, санал асуулгууд нь ТББ-ыг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны болон ажилтнуудын ур чадварын асуудлуудыг гол төлөв хөндөж байжээ. Харин өнөөг хүртэл ТББ-уудын өнөөгийн байдал, технологийн түвшин, Интернэт ашиглалт, мэдээллийн хэрэгцээ, шаардлага зэрэг асуудлыг хөндсөн судалгаа, санал асуулга хийгдээгүй ирснийг дурдах хэрэгтэй.

МННХ (Соросын сан)–гээс ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл холбооны технологийн хэрэглээг өргөжүүлэх замаар ТББ-уудын үйл ажиллагааг сайжруулах, тэдний зүгээс иргэний нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх, мэдээллийн чөлөөт урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор 1998 оны арванхоёрдугаар сард Нээлттэй Мэдээлэл Төвийг (НМТ) байгуулсан юм. НМТ төслийн хүрээнд ТББ-уудын технологи, компьютер, Интернет ашиглалтыг сайжруулах үүднээс өргөн хүрээтэй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн билээ. Тус сангаас НҮБХХ–тэй хамтран Монголын ТББ-уудын мэдээллийн санг байгуулж, Вэб хуудсуудыг Нээлттэй Мэдээлэл Төвийн Вэб сервер дээр байршуулж байна. ТББ-уудын Мэдээллийн Сан байгуулах төслийн хүрээнд 2700 гаруй ТББ-ын мэдээлэл бүхий лавлах ном болон СД гаргасан юм. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд ТББ-уудад зориулсан олон тооны сургалтыг зохион байгуулж, компьютерийн хэрэглээ, Вэб хуудас хийх талаархи зааварчилгаа, зөвлөмж зэргийг бэлтгэн ТББ-уудад түгээсэн байна. Өдгөө НМТ-ийн Вэб сервер дээр 200 гаруй ТББ Вэб хуудсаа байршуулж, ТББ-уудын мэйл серверийн тусламжтай харилцан мэдээлэл, туршлага солилцож байна.

## АГУУЛГА

<u>1. Судалгааны танилцуулга .....</u>	<u>4</u>
<u>1.1 Судалгааны аргачлал .....</u>	<u>5</u>
<u>1.2 Судалгаа .....</u>	<u>5</u>
<u>2. ТББ-уудаас гарсан санал .....</u>	<u>13</u>
<u>3. Дүгнэлт .....</u>	<u>14</u>
<u>3.1 Судалгааны үр дүн .....</u>	<u>14</u>
<u>3.2 Дүгнэлт .....</u>	<u>15</u>
<u>3.3 Зөвлөмж .....</u>	<u>16</u>
<u>4. Хавсралт .....</u>	<u>17</u>
<u>Санал асуулгын загвар .....</u>	<u>17</u>

## 1. Судалгааны танилцуулга

МННХ (Соросын сан)–гийн НМТ-өөс ТББ-уудын үйл ажиллагааны өнөөгийн түвшин, мэдээлэл ба Интернет ашиглалт, компьютерийн боломж, мэдээллийн хэрэгцээ шаардлага, мэдээлэл солилцох чадвар, боломж зэргийг тодорхойлох зорилгоор санал асуулга явуулсан юм. Энэхүү судалгаа нь Монголын ТББ-уудын сүлжээ - Нээлттэй Мэдээлэл Төв Вэб хуудсаар дамжуулан ТББ-уудад хэрэгтэй мэдээ мэдээллийг хүргэх, үйл ажиллагааг нь дэмжихэд хувь нэмэр оруулах юм.

Судалгааг 2003 оны хоёрдугаар сарын 15-наас дөрөвдүгээр сарын 01 хүртэлх хугацаанд явуулав. Судалгаанд нийт 188 ТББ, үүнээс Улаанбаатар хотоос 172 ТББ, Багануур, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ болон Төв аймгуудаас 16 ТББ хамрагдсан болно. Үйл ажиллагааны чиглэлээр ангилан харуулбал:

№	Үйл ажиллагааны чиглэл	Тоо	Эзлэх хувь
1.	Хүүхэд, залуучууд	26	13.83%
2.	Жендер, гэр бүл	23	12.23%
3.	Хүний эрх, иргэний нийгэм, ардчилал	20	10.64%
4.	Нийгмийн халамж, эмзэг бүлэг болон тахир дутуу иргэд	18	9.57%
5.	Эдийн засаг, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ	17	9.04%
6.	Спорт, аялал жуулчлал, чөлөөт цаг	14	7.45%
7.	Боловсрол, шинжлэх ухаан, технологи, судалгаа	14	7.45%
8.	Мэдээлэл, олон нийтийн хэвлэл мэдээлэл	10	5.32%
9.	Олон улсын найрамдал, хамтын ажиллагаа	10	5.32%
10.	Эрүүл мэнд	9	4.79%
11.	Мэргэжил, сонирхлын бүлгүүд	9	4.79%
12.	Хууль эрх зүй	6	3.19%
13.	Байгаль орчин, байгалийн гамшиг	5	2.66%
14.	Соёл урлаг, утга зохиол, түүх дурсгал	4	2.13%
15.	Ахмад	2	1.06%
16.	Бүс нутаг, орон нутгийн хөгжил	1	0.53%

ТББ-уудын хамаарах хувиас харахад, судалгаанд оролцсон байгууллагууд ангилал тус бүрийн төлөөлөгчдөөс ялгарах томоохон ялгаа байхгүй байна.

### 1.1. Судалгааны аргачлал

Нээлттэй Мэдээлэл Төвөөс тайлангийн 1-р хавсралтад орсон санал асуулгыг боловсруулж, Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 400 гаруй ТББ-уудад хувь хүн, шуудан, и-мэйл болон ТББ-уудын и-мэйлийн ngos@owc.org.mn. нэгдсэн сүлжээгээр тарааж, ТББ-уудад санал асуулгын хуудсыг онлайн хэлбэрээр бөглөх боломжийг бүрдүүлсэн байна.

400 гаруй ТББ-уудаас санал асуулгын хариуг 188 ТББ, үүнээс 163 буюу 87 хувь нь цаасаар, 17 буюу 13 хувь нь онлайн хэлбэрээр тус тус өгчээ.


### 1.2. Судалгаа

Санал асуулга нь нийт 12 асуулт бүхий үндсэн хоёр хэсгээс бүрдэж байна. Санал асуулгын эхний хэсэгт ТББ-ын одоогийн статус, компьютер, Интернет, технологи ашиглалтын тухай асуултууд багтсан бол хоёрдугаар хэсэгт тухайн ТББ нь НМТ-ийн Вэб хуудсыг хэрхэн ашигладаг, тэдэнд ямар төрлийн мэдээлэл хэрэгтэй байгаа, НМТ-ийн Вэб хуудсын агуулгын талаархи асуултуудыг багтаажээ.


Санал асуулгын үр дүнг хүснэгт болон диаграммын аргаар илэрхийлэн харуулсан болно.

№	Асуулт	Хувилбарууд	Тоо хэмжээ	Эзлэх хувь
			188	100%
1	Та Интернет ашиглаж чадах уу?	1. Сайн	90	47.84%
		2. Дунд зэрэг	63	33.51%
		3. Чаддаггүй	24	12.77%
		4. Огт ажиллаж үзээгүй	9	0.47%
		5. Хариулаагүй	2	0.106%
		Нийт	188	100%

Судалгаанд оролцсон нийт 188 ТББ-аас 47.84 хувь нь Интернетийг сайн хэрэглэж чаддаг, 33.51 хувь нь дунд зэрэг, 0.47 хувь нь огт ашиглаж үзээгүй, 12.77 хувь нь ажиллаж чаддаггүй хэмээн хариулжээ. Харин 0.1 хувь нь асуултанд хариулаагүй байна (Диаграмм 1).




2	Та Интернэт хэр их хэрэглэдэг вэ?	1. Өдөр бүр	73	38.83%
		2. Долоо хоног бүр	47	25.00%
		3. Сар бүр	50	26.60%
		4. Хариулаагүй	18	9.57%
		Нийт	188	100%



Дээрх асуултанд нийт судалгаанд оролцогчдын 38.83 хувь нь өдөр бүр Интернэт хэрэглэдэг, 25 хувь нь долоо хоног бүр, 26.6 хувь нь сар бүр, 9.57 хувь нь асуултанд хариулаагүй байна (Диаграмм 2).

3	Та Интернэтэд ямар холболтоор холбогддог вэ?	1. Модем (Dial-up)	92	48.94%
		2. DSL/Cable	12	6.38%
		3. Дотоод сүлжээ- LAN	47	25.00%
		4. Хариулаагүй	33	19.68%
		Нийт	188	100%


Судалгаанд оролцогчдын 48.94 хувь нь модемоор, 25.00 хувь нь дотоод сүлжээгээр, 6.38 хувь нь DSL/Cable ашиглан Интернэтэд холбогддог гэж тус тус хариулсан байна (Диаграмм 3).



**Диаграмм 3**


4	Та Интернэтээс ямар төрлийн мэдээлэл авахыг илүү их сонирхдог вэ? (хэдэн ч хариулт сонгож болно)	1. ТББ-уудын мэдээллийн бааз	100	53.19%
		2. Олон улс ба дотоодын бага хурал, семинар, үйл явдлын талаархи мэдээ	100	53.19%
		3. Сургалт, зөвлөгөө	98	52.13%
		4. Донор байгууллагуудын талаархи мэдээ	81	43.09%
		5. ТББ-уудын хаяг	79	42.02%
		6. Шинжлэх ухаан, боловсрол	74	39.36%
		7. Хууль зүй	70	37.23%
		8. Улс төр	65	34.57%
		9. Соёл урлаг, спорт	59	31.38%
		10. Нийгэм	58	30.85%
		11. Арилжаа, сурталчилгаа	38	20.21%
		12. Бусад мэдээлэл	37	19.68%
		13. Хариулаагүй	4	2.13%
		Нийт	863	

Дээрх асуултанд нийт ТББ-уудын дийлэнх нь буюу 100 ТББ “ТББ-уудын мэдээллийн сан”, 100 ТББ “Олон улс ба дотоодын бага хурал, семинар, үйл явдлын талаархи мэдээ”, 98 ТББ “Сургалт, зөвлөгөө”, 81 ТББ “Донор байгууллагуудын талаархи мэдээ”, 79 ТББ “ТББ-ууд”-ын тухай мэдээлэл авах хүсэлтэй гэж хариулсан бөгөөд 4 ТББ асуултанд хариулаагүй. Бусад мэдээлэл гэсэн хэсэгт ТББ-уудаас гаргасан саналуудыг судалгааны



5	Та Интернэтийн ямар төрлийн үйлчилгээг ашигладаг вэ?	1. И-мэйл	144	76.60%
		2. Вэб	113	60.11%
		3. Chat	36	19.15%
		4. FTP (файл татаж авах)	25	13.30%
		5. Зайны сургалт	20	10.64%
		6. Discussion group (ярилцлага)	19	10.11%
		7. Хариулаагүй	19	10.11%
		8. Usenet (хэрэглэгчийн хэсэг)	18	9.57%
		9. Telnet (мэдээлэл дамжуулах)	13	6.91%
		10. Бусад	12	6.38%
		Нийт	419	

Судалгаанд оролцогчид и-мэйл (144 ТББ), Вэбийн (113 ТББ) үйлчилгээнүүдээс гадна FTP (25 ТББ) болон, Telnet (13 ТББ) үйлчилгээг ашигладаг байна (Диаграмм 5).




6	Танай байгууллага Вэб хуудастай юу?	1. Тийм	102	54.26%
		2. Үгүй	78	41.49%
		3. Хариулаагүй	8	4.26%
		Нийт	188	100%

Нийт оролцогчдын 54.26 хувь нь Вэб хуудастай, 41.49 хувь нь Вэб хуудасгүй гэсэн хариултыг тус тус өгчээ (Диаграмм 6).



7	Танай байгууллага НМТ-ийн Вэб хуудсаар дамжуулан ямар төрлийн мэдээллийг олон нийтийн хүртээл болгох боломжтой вэ?	1. Мэдээ, мэдээлэл	114	60.64%
		2. Сургалт, гарын авлага	69	36.70%
		3. Зөвлөмж, үйлчилгээ	69	36.70%
		4. Бага хурал, семинар	43	22.87%
		5. Хичээлүүд	37	19.68%
		6. Мэдээллийн баазын холбоос	20	10.64%
		7. Хариулаагүй	19	10.11%
		8. Бусад	12	6.38%
		Нийт	383	

Нийт 144 ТББ мэдээ, мэдээлэл, 69 ТББ сургалт, гарын авлага, зөвлөмж үйлчилгээ, 43 ТББ хурал, семинар, 37 ТББ мэдээллийн сангийн холбоосын тухай мэдээ мэдээллийг өгөх боломжтой гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 4.96 хувь нь болох 19 ТББ асуултанд хариу өгөөгүй. Бусад гэсэн хэсэгт ирүүлсэн саналыг судалгааны тавдугаар хэсгээс үзнэ үү (Диаграмм 7).



**Диаграмм 7**


8	НМТ-ийн Вэб хуудсыг хэрэглэж байсан уу?	1. Тийм	73	38.83%
		2. Үгүй	104	55.32%
		3. Хариулаагүй	11	5.85%
		Нийт	188	100%

Судалгаанд оролцсон ТББ-уудын 38.83 хувь нь Нээлттэй Мэдээлэл Төвийн Вэб хуудсыг хэрэглэж байсан, 55.32 хувь нь хэрэглэж байгаагүй гэж хариулсан байна. 5.85 хувь нь асуултанд хариулаагүй (Диаграмм 8).



**Диаграмм 8**

9	Та Нээлттэй Мэдээлэл Төвийн Вэб сайтаас хэрэгтэй мэдээллээ авч чадсан уу?	1. Тийм	72	38.30%
		2. Үгүй	77	40.96%
		3. Хариулаагүй	39	20.74%
		Нийт	188	100%




**Диаграмм 9**

Нээлттэй Мэдээлэл Төвийн Вэб хуудаснаас хэрэгцээт мэдээллээ авч чадсан уу гэсэн асуултанд 38.30 хувь нь тийм, 40.96 хувь нь үгүй гэсэн хариултыг тус тус өгсөн байна. 20.74 хувь нь уг асуултанд хариулаагүй байна (Диаграмм 9).

10	Хэрэв авсан бол ямар мэдээлэл авсан бэ?	1. Хариулаагүй	104	55.32%
		2. ТББ-уудын мэдээ	55	29.26%
		3. ТББ-уудын мэдээллийн бааз	23	12.23%
		4. Хичээлүүд	21	11.17%
		5. Сонин	20	10.64%
		6. Цахим номын сан	16	8.51%
		7. Бусад	11	5.85%
		8. Listserve – мэдээллийн түгээгч	8	4.26%
		Нийт	258	


55.32 хувь хариулаагүй. 29.26 хувь нь “ТББ-уудын мэдээ”, 12.23 хувь нь “ТББ-уудын мэдээллийн сан”, 11.17 хувь нь “Хичээлүүд”-ийн тухай мэдээллийг авч чадсан гэж хариулжээ (Диаграмм 10).

**Диаграмм 10**



11	Нээлттэй Мэдээлэл Төвийн Вэб хуудсыг сайжруулах хэрэгтэй юу? Хэрэв тийм бол загвар, агуулга дээр нь ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?	1. Хариулаагүй	68	36.17%
		2. Сүүлийн үеийн үйл явдал, үйл ажиллагаа	53	28.19%
		3. ТББ-уудын тухай мэдээлэл	50	26.60%
		4. Шинэчлэгдсэн мэдээллийн бааз	32	17.02%
		5. Мэдээ, мэдээлэл бүхий материал	32	17.02%
		6. Өөрчлөх хэрэггүй, шаардлага хангадаг	12	6.38%
		7. Өөр ямар шинэлэг зүйлийг нэмж өөрчилж болох вэ?	6	3.19%
		Нийт	253	


6.38 хувь нь өөрчлөх шаардлагагүй, 28.19 хувь нь цаг үеийн үйл явдал, үйл ажиллагаа, 26.60 хувь нь ТББ-уудын тухай мэдээ, мэдээлэл, 17.02 хувь нь шинэчлэгдсэн мэдээллийн сан, 17.02 хувь нь мэдээ, мэдээлэл бүхий материалыг тус тус сайжруулах хэрэгтэй гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 36.17 хувь нь асуултанд хариулаагүй. Өөр ямар шинэлэг зүйлийг нэмж өөрчлөх хэрэгтэй вэ? хэсэгт ирсэн саналыг судалгааны тавдугаар хэсгээс үзнэ үү (Диаграмм 11).



**Диаграмм 11**

12	Дээрх төрлийн мэдээллийг ямар хэлбэрээр өгөх боломжтой вэ?	1. Электрон хэлбэрээр	87	46.28%
		2. Цаасан хэлбэрээр	77	40.96%
		3. Хариулаагүй	37	19.68%
		Нийт	201	

Судалгаанд оролцогчдын 46.28 хувь нь электрон хэлбэрээр, 40.96 хувь нь цаасан хэлбэрээр мэдээлэл өгөх боломжтой гэж хариулсан байна (Диаграмм 12).



**Диаграмм 12**

## 2. ТББ-уудын санал

Энэ хэсэгт ТББ-уудаас дор дурдсан асуултуудад өгсөн санал, зөвлөмжүүдийг нэгтгэсэн болно. Үүнд, Асуулт 4: “Та Интернетээс ямар төрлийн мэдээлэл авахыг илүү их сонирхдог вэ?”, Асуулт 7: “Танай байгууллага НМТ-ийн Вэб хуудсаар дамжуулан ямар төрлийн мэдээллийг олон нийтийн хүртээл болгох боломжтой вэ?”, Асуулт 11: “НМТ-ийн Вэб хуудсыг сайжруулах хэрэгтэй юу? Хэрэв тийм бол загвар, агуулга дээр нь ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?”

**Асуулт 4.** Та Интернетээс ямар төрлийн мэдээлэл авахыг илүү их сонирхдог вэ?

№	Байгууллагын нэр	Хариулт
1	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо	Байгууллагынхаа үйл ажиллагаатай холбоотой
2	Монголын “Перинатологи” нийгэмлэг	Мэргэжлийн талын мэдээлэл
3	Монголын тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоо	ТББ-уудын үйл ажиллагааны талаар
4	Өсвөр үе - ирээдүй төв	Нөхөн үржихүйн эрүүл мэнд, ДОХ, БЗХӨ, өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд
5	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	Гэр бүлийн хүчирхийлэл
6	ДОХ-той тэмцэх үндэсний сан	ХДХВ/ДОХ болон БЗХӨ, түүнээс урьдчилан сэргийлэх
7	Газар тариаланг хөгжүүлэх сан	Хөдөө аж ахуй
8	Мэри Стопс Интернэйшнэл	- Нөхөн үржихүйн эрүүл мэнд - Балгэвч хэрэглээ
9	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн асуудал
10	Монголын ажил хэрэгч тахир дутуу иргэдийн холбоо	Нөхөн үржихүйн эрүүл мэнд, ДОХ/ХДХВ, БХХӨ г.м.
11	Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг	- Хар тамхи мансууруулах бодис, ургамлын хор үндэс - Архи, тамхи - Сэтгэц нөлөөт эм, хар тамхи - хор хөнөөл - Олон улсын энэрлийн байгууллага - НҮБ-ын хяналт тавих хөтөлбөр

**Асуулт 7.** Танай байгууллага НМТ-ийн Вэб хуудсаар дамжуулан ямар төрлийн мэдээллийг олон нийтийн хүртээл болгох боломжтой вэ?

№	Байгууллагын нэр	Хариулт
1	ДОХ-той тэмцэх үндэсний сан	ХДХВ/ДОХ болон БЗХӨ, түүнээс урьдчилан сэргийлэх талаар
2	“Хөдөөгийн Пэрлээ” сан	Судалгаа шинжилгээ

**Асуулт 11.** НМТ-ийн Вэб хуудсыг сайжруулах хэрэгтэй юу? Хэрэв тийм бол загвар, агуулга дээр нь ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?

№	Байгууллагын нэр	Хариулт
1	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо	Тухайн байгууллагынхаа үйл ажиллагаатай холбоотой
2	Монголын Жудо бөхийн холбоо	Цаг үеэсээ хоцрохгүй шинээр дандаа сэргээж байх
3	Монголын тахир дутуу иргэдийн холбоо	Олон улсын тахир дутуу иргэдийн ТББ- уудын мэдээ мэдээлэл, Вэб хуудасны танилцуулга
4	Хэвлэлийн хүрээлэн	Хялбар хайлтын систем
5	Монголын загас сонирхогчдын спортын нийгэмлэг	Монголын загас сонирхогчдын спортын тухай мэдээлэл оруулах
6	Монголын каноэгийн холбоо	Монголын каноэгийн холбооны тухай мэдээлэл оруулах
7	Монголын спорт аяллын холбоо	Монголын адал явдалт спорт аяллын холбооны тухай мэдээлэл оруулах
8	Монголын ногоонтны хөдөлгөөн	Монголын ногоонтны хөдөлгөөний мэдээлэл хуучирсныг шинэчлэх
9	Дашбалбар сан	Уран бүтээл, хэвлэл мэдээлэл
10	Монголын түүх соёлын дурсгалыг хамгаалах Марал-Од төв	Олон улсын болоод бусад ТББ-уудтай хамтарч ажиллах талаар

### 3. Дүгнэлт

#### 3.1 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Мэдээлэл холбооны технологи нь Монголын ТББ-уудын хувьд харьцангуй шинэлэг зүйл хэдий ч мэдээлэл холбооны технологийг ашигладаг ТББ-уудын тоо улам бүр өсч байна. Энэ нь санал асуулгад оролцогчдын 48 хувь буюу 90 ТББ Интернэтийг сайн ашигладаг, 38 хувь нь Интернэтэд өдөр тутам холбогддог, 18 байгууллага буюу ердөө 9 хувь нь энэ асуултанд хариулаагүй байгаагаас харагдаж байна.

ТББ-уудын ихэнх буюу санал асуулгад хариу ирүүлэгсдийн 50 хувь нь Интернэтэд модемоор холбогддог. 25 хувь буюу 47 ТББ Интернэтэд холбогдох орон нутгийн зардал өндөр байгааг тэмдэглэсэн нь ихээхэн сонирхол татаж байна. Бидний олж мэдсэн хамгийн сонирхолтой зүйл гэвэл 12 ТББ Интернэтэд DSL/кабелиар холбогдох боломжтой хэдий ч энэ нь манай нөхцөлд өндөр өртөгтэй байгаа юм. (Сар тутам телефон утсанд 150,00 төгрөг, дээр нь Интернэтийн холболтын зардалд 150,000 төгрөг төлдөг).

Ямар төрлийн мэдээлэл хэрэгцээтэй байдаг вэ? гэсэн асуултанд ТББ-ууд хамгийн дэлгэрэнгүй хариултыг өгсөн байна. Хариултаас харахад, бүхий л төрлийн мэдээлэл, тэр дундаа ТББ-уудын мэдээллийн сан, олон улсын болон дотоодын хурал, семинар, сургалт, шинжлэх ухаан, боловсрол, хууль, улс төр, соёл урлаг, спорт, иргэний нийгэм, тэр ч бүү хэл зар сурталчилгааны талаархи мэдээллүүд хэрэгцээтэй байдаг гэжээ. ТББ-ууд ижил чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад ТББ-уудын талаархи мэдээлэл, тэдний үйл ажиллагаа, тухайлбал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хөдөөгийн эмэгтэйчүүдийн асуудлууд, ДОХ, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, бэлгэвчийг зохистойгоор хэрэглэх, өсвөр үеийнхний нөхөн үржихүй, мансууруулах бодис, тамхи, архи, мансууруулах үйлчилгээтэй эмийн бүтээгдэхүүн, өвс ургамлын тухай г.м. мэдээллийг илүү сонирхож байв.

Интернэтийн үйлчилгээтэй холбоотой асуултуудын тухайд, ТББ-уудын ихэнх нь Интернэт ашигладаг, тухайлбал давхардсан сонголттой хариултаас үзвэл 77 хувь нь и-мэйл, 60 хувь нь Вэбийг илүү хэрэглэдэг гэж хариулсан байна. Нэлээд олон ТББ-ууд чат, Интернэт хэлэлцүүлэг, зайны сургалт, Телнет зэрэг өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмж шаардсан үйлчилгээг хэрэглэдэг гэж хариулжээ.

Вэб хуудасны тухайд Вэб хуудастай болон хуудасгүй ТББ-уудын тоо бараг тэнцүү байв. Санал асуулгад хариу ирүүлэгсдийн 54 хувь буюу 102 ТББ Вэб хуудастай байна.

ТББ-уудын талаархи мэдээллийг НМТ-ийн Вэбээр дамжуулан түгээж буй асуудал дээр ТББ-уудын дийлэнх буюу 114 байгууллага (61 хувь) нь сайшааж буйгаа илэрхийлжээ. Олон ТББ-ууд олон нийтийн дунд сургалт явуулах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх сонирхотой байдаг, зарим нь бага хурал, хичээл сургалт, мэдээллийн сантай холбоотой мэдээллээр

хангаж чадахаа илэрхийлсэн байна. Тухайлбал, таван ТББ-ын тайланд тодорхой үйл ажиллагааны хүрээнд, жишээлбэл, ДОХ-той тэмцэх талаар судалгааны ажил дээрээ түшиглэн энэ талаар бусадтай санал бодлоо хуваалцах хүсэлтэй байгаагаа тусгажээ.

НМТ-ийн Вэб хуудасны тухайд ТББ-уудын ихэнх нь тус Вэб хуудсыг мэддэг, хэрэглэдэг гэж хариулсан байна. Гэхдээ тус санал асуулгад хариулагсдын 55 хувь (104 ТББ) нь НМТ-ийн Вэб хуудастай холбогдох боломжгүй гэж хариулжээ. ТББ-уудын ихэнх нь НМТ-ийн Вэб хуудсанд холбогдох боломжгүй тул тэдний 41 хувь нь буюу 77 ТББ нь НМТ-ийн Вэбийг огт мэддэггүй гэж хариулах нь ойлгомжтой юм. Үүнийг бид уг санал асуулгад хариулаагүй 20 хувиас илүү онцолж авч үзэх нь зүйтэй юм.

Мөн ТББ-уудын талаархи мэдээллүүд, мэдээллийн сан, сонин, электрон номын сан, болон бусад мэдээллийг сонирхдог байна.

ТББ-уудын ихэнх нь НМТ-ийн Вэбтэй холбогдох боломжгүй байгаагаас үндэслэн дараачийн асуултууд нь ТББ-уудад зориулсан Вэб хуудасны агуулгыг сайжруулахад чиглэгдсэн байв. НМТ-ийн Вэб хуудасны агуулга ба дизайныг сайжруулах тал дээр асуулгад оролцогсод тус төвийн Вэб хуудсыг байнга шинэчлэх, ТББ-уудтай холбоотой шинэ сэргэг мэдээллийг цаг алдалгүй мэдээлж байхыг хүсчээ. 68 ТББ буюу 37 хувь нь энэ асуултанд хариулаагүй байна.

НМТ-ийн Вэб хуудсыг хэрэгцээтэй, интерактив болгохын тулд ТББ-аас тус Вэб сайтад тавих мэдээллүүд ямар байх талаархи асуултанд 46 хувь нь мэдээллийг электрон, 41 хувь нь цаасан хэлбэрээр хүргэх нь илүү үр дүнтэй гэж хариулсан байв.

### **3.2 ДҮГНЭЛТ**

Дээр дурдсанчлан тус санал асуулга нь ТББ-уудын мэдээлэл холбооны технологийн хэрэглээний өнөөгийн түвшинг судлан тогтоох, тэдэнд хэрэгцээтэй мэдээллийг НМТ-ийн Вэб хуудсаар дамжуулан хүргэх зорилготой байсан билээ.

Судалгааны үр дүнг доорхи байдлаар нэгтгэн дүгнэж байна. Үүнд:

1. ТББ-уудын тодорхой хэсэг нь МХТ-ийг ашиглах хүчин чадал бүхий компьютер, сүлжээ, Интернэт холболттой.
2. Нийт ТББ-ууд Интернэтийн холболт ба сүлжээний үйлчилгээнд хамрагдаж чадаагүйн улмаас Интернэт, электрон шуудан, чат болон бусад үйлчилгээг хүртэж чаддаггүй.
3. ТББ-ууд үйл ажиллагааныхаа чиглэлээр бусад байгууллагуудад өөрсдийн олж авсан мэдээллийг түгээх, харилцан солилцох сонирхол, хүсэлтэй байдаг.
4. ТББ-уудад мэдээлэл дутмаг байдаг. Тухайлбал, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад ТББ-ууд болон хандивлагч байгууллагууд,

сургалт, зөвлөгөө, ДОХ, мансууруулах бодисийн хэрэглээний талаархи мэдээлэл г.м.

5. ТББ-уудад МХТ-ийг нэвтрүүлэх, боловсон хүчний компьютерийн хэрэглээний ур чадварыг дээшлүүлэх, Вэб хуудас бүтээхэд нь тусламж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

6. НМТ-ийн Вэб хуудас нь ТББ-уудын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. (Зөвхөн 38.3 хувь нь хэрэгцээт мэдээллээ олж авч чаддаг).

7. ТББ-уудын эрэлт хэрэгцээг хангахуйц мэдээллийг боловсруулах, арга зүйг бий болох шаардлагатай байна.

### 3.3 ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүн дээр үндэслэн ТББ-ууд, тэдэнтэй хамтран ажилладаг, байгууллагуудад доорхи зөвлөмжийг санал болгож байна.

1. ТББ-уудад компьютер болон Вэб хуудастай ажиллахаар зааварчилгаа, тэдний сонирхолд нийцсэн мэдээллийг хүргэх.

2. ТББ-уудын мэдээллийг хүлээн авч хадгалан бусад байгууллагуудад ашиглуулах боломжийг олгох орчинг бий болгох.

3. НМТ-ийн Вэб хуудсыг яаралтай шинэчилж, ТББ-уудад хэрэгцээтэй мэдээллийг оруулах, тус Вэбээр дамжуулан ТББ-ууд мэдээллээ харилцан солилцох боломжийг бүрдүүлэх.

Үүний тулд дор дурдсан зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

а. Интернэтэд холбогдохын тулд ихэнх ТББ-ууд 50 хувь модем хэрэглэдэг байна. Улаанбаатар хотод Интернэтийн хурд 44,000 kbps, хөдөө орон нутагт үүнээс хавьгүй удаан байгаа нөхцөлд НМТ-ийн Вэб хуудсыг нөхцөл байдалд тохируулан хөгжүүлэх шаардлагатай.

б. ТББ-ууд мэдээллээ бусадтай хуваалцах сонирхолтой байгааг харгалзан үзэж зохих судалгааг хийх, техникийн туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

в. ТББ-уудыг НМТ-ийн электрон шуудангийн сүлжээнд нэгтгэх, тэдний хаягийг серверийн бүртгэлд оруулах нь зүйтэй.

г. ТББ-уудын мэдээллийн санг бий болгон баяжуулах, энэ ажилд ТББ-уудыг татан оролцуулбал зохино.

д. ТББ-уудад Вэб хуудсаа шинэчлэх, сайжруулахад нь байнгын зөвлөгөө өгөх, туслан дэмжих шаардлагатай.

е. НМТ-ийн Вэб хуудас нь ТББ-уудын хэрэгцээ шаардлага, ашиг сонирхолд нийцсэн байх нь зүйтэй. Нэг ТББ-аас зохион байгуулж буй ажлын талаар бусад ТББ-ууд судлах, харилцан мэдээлэл, туршлага солилцохыг дэмжих гэх мэт.

## Санал асуулгын заавар

### НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ ТӨВ ([www.owc.org.mn](http://www.owc.org.mn)) Вэб хуудас болон түүний агуулгын талаархи санал асуулга

*Санал асуулгад оролцож байгаа Танд баярлалаа*

ТББ-уудын онлайн мэдээллийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, Нээлттэй Мэдээлэл Төвийн (НМТ) Вэб сайт болон түүний агуулгыг сайжруулах зорилгоор энэхүү санал асуулгыг явуулж байна. Та сонгосон хариултаа (✓) гэж тэмдэглэнэ үү.

- Байгууллагын нэр: \_\_\_\_\_

- Хаяг: \_\_\_\_\_

- Утас # \_\_\_\_\_ Факс # \_\_\_\_\_

- И-мэйл: \_\_\_\_\_

- Вэб сайт: <http://>\_\_\_\_\_

1. Та Интернет ашиглаж чадах уу?

- |                                     |  |
|-------------------------------------|--|
| <input type="checkbox"/> Сайн       | <input type="checkbox"/> Чаддаггүй           |
| <input type="checkbox"/> Дунд зэрэг | <input type="checkbox"/> Огт ажиллаж үзээгүй |

2. Та Интернет хэр их хэрэглэдэг вэ?

- |  |                                  |
|--|----------------------------------|
| <input type="checkbox"/> Өдөр бүр        | <input type="checkbox"/> Сар бүр |
| <input type="checkbox"/> Долоо хоног бүр |                                  |

3. Та Интернетэд ямар холболтоор холбогддог вэ?

- |  |  |
|--|--|
| <input type="checkbox"/> Модем (Dial-up) | <input type="checkbox"/> Дотоод сүлжээ-LAN |
| <input type="checkbox"/> DSL/Cable       |  |

4. Та Интернетээс ямар төрлийн мэдээлэл авахыг илүү их сонирхдог вэ? (хэдэн ч хариулт сонгож болно)

- |   |  |
|---|--|
| <input type="checkbox"/> Шинжлэх ухаан  | <input type="checkbox"/> Улс төр                   |
| <input type="checkbox"/> Соёл урлаг, спорт  | <input type="checkbox"/> Нийгэм                    |
| <input type="checkbox"/> Хууль зүй  | <input type="checkbox"/> Сургалт, зөвлөгөө         |
| <input type="checkbox"/> ТББ-ууд  | <input type="checkbox"/> Арилжаа, зар сурталчилгаа |
| <input type="checkbox"/> ТББ-уудын мэдээллийн сан   |  |
| <input type="checkbox"/> Олон улсын болоод дотоодын хурал, семинар, үйл явдлын тойм мэдээ |  |
| <input type="checkbox"/> Донор байгууллагуудын талаархи мэдээ                             |  |
| <input type="checkbox"/> Бусад мэдээлэл _____   |  |

5. Та Интернэтийн ямар төрлийн үйлчилгээнүүдийг ашигладаг вэ?
- |  |   |
|--|---|
| <input type="checkbox"/> Вэб           | <input type="checkbox"/> Usenet (хэрэглэгчийн хэсэг)  |
| <input type="checkbox"/> И-мэйл        | <input type="checkbox"/> Discussion group (ярилцлага) |
| <input type="checkbox"/> Зайны сургалт | <input type="checkbox"/> FTP (файл татаж авах)        |
| <input type="checkbox"/> Chat          | <input type="checkbox"/> Telnet (мэдээлэл дамжуулах)  |
| <input type="checkbox"/> Бусад _____   |   |
6. Танай байгууллага Вэб хуудастай юу?
- |                               |                               |
|-------------------------------|-------------------------------|
| <input type="checkbox"/> Тийм | <input type="checkbox"/> Үгүй |
|-------------------------------|-------------------------------|
7. Танай байгууллага НМТ-ийн Вэб хуудсаар дамжуулан ямар төрлийн мэдээллийг олон нийтийн хүртээл болгох боломжтой вэ?
- |  |   |
|--|---|
| <input type="checkbox"/> Сургалт, гарын авлага | <input type="checkbox"/> Мэдээллийн сангийн холбоос |
| <input type="checkbox"/> Хурал, семинар        | <input type="checkbox"/> Мэдээ, мэдээлэл            |
| <input type="checkbox"/> Хичээлүүд             | <input type="checkbox"/> Зөвлөмж, үйлчилгээ         |
| <input type="checkbox"/> Бусад _____           |   |
8. НМТ-ийн Вэб хуудсыг хэрэглэж байсан уу?
- |                               |                               |
|-------------------------------|-------------------------------|
| <input type="checkbox"/> Тийм | <input type="checkbox"/> Үгүй |
|-------------------------------|-------------------------------|
9. Та НМТ-ийн Вэб сайтаас хэрэгтэй мэдээллээ авч чадсан уу?
- |                               |                               |
|-------------------------------|-------------------------------|
| <input type="checkbox"/> Тийм | <input type="checkbox"/> Үгүй |
|-------------------------------|-------------------------------|
10. Хэрэв авч чадсан бол ямар мэдээлэл авсан бэ?
- |   |   |
|---|---|
| <input type="checkbox"/> ТББ-уудын мэдээ          | <input type="checkbox"/> Цахим номын сан              |
| <input type="checkbox"/> Хичээлүүд                | <input type="checkbox"/> Listserve – мэдээлэл түгээгч |
| <input type="checkbox"/> ТББ-уудын мэдээллийн сан | <input type="checkbox"/> Сонин                        |
| <input type="checkbox"/> Бусад                    |   |
11. НМТ-ийн Вэб хуудсыг сайжруулах хэрэгтэй юу? Хэрэв тийм бол загвар, агуулга дээр нь ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?
- |  |
|--|
| <input type="checkbox"/> Мэдээлэл, мэдээлэл бүхий материал   |
| <input type="checkbox"/> Шинэчлэгдсэн мэдээллийн сан   |
| <input type="checkbox"/> Цаг үеийн үйл явдал, үйл ажиллагаа  |
| <input type="checkbox"/> ТББ-уудын тухай мэдээлэл  |
| <input type="checkbox"/> Өөрчлөх хэрэггүй, шаардлага хангадаг                                      |
| <input type="checkbox"/> Өөр ямар шинэлэг зүйлийг нэмж өөрчилж болох вэ? Та өөрийн саналыг өгнө үү |
| .....  |
12. Дээрх төрлийн мэдээллүүдийг ямар хэлбэрээр өгөх боломжтой вэ?
- |   |
|---|
| <input type="checkbox"/> Цаасан хэлбэрээр   |
| <input type="checkbox"/> Электрон хэлбэрээр |

*Танд баярлалаа.*